

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

7-Р АНГИ

“А” Хувилбар

Сурагчийн нэр:

75 настай “шилдэг менежер”

Манайх одоо 4000 малтай. Угтаа бол малчин хүний хөдөлмөр, малын буян, аав, ээж, өвөг дээдсийн буян ингэж өсөж дэлгэрэх учиртай юм. Мал сүрэг малчин хүний алдар хүндийн тодорхойлолт болж явдаг. 75 нас хүрч байгаа намайг мал аж ахуйн салбараас анх удаа “Шилдэг менежер” болгосонд талархаж байна.

... Уламжлалт бус аж ахуйг эрхлэх гэж оролдож байна. Таван төрлийн малыг нэг дор, нэг бэлчээрт малладаггүй байсан. Дөрөв, тавдугаар сард адууг богино бэлчээрийн гадна талд алсын оторт малладаг. Адууг 150-160 хоногийн хугацаанд богино хөлийн малын бэлчээрийн гарцын гадна аваачиж маллахаар бэлчээрийн даац хүндрэхгүй. Адуу нв хонь, ямаа, үхэр, тэмээтэй адил хивдэггүй учраас хоногт хориод цаг идэж, 3-4 цаг босоогоороо унтдаг амьтан. Бэлчээртэй харьцах, энэ асуудал Монголд том онол. Энэ мэт монгол ухаан, монгол сэтгэлгээ орхигдсоор байна.

Монголчууд шиг байгаль эх дэлхий, малаа дээдэлдэг ард түмэн дэлхийд байхгүй. Үндэснийхээ соёл, зан үйл, хэв маягаас салсан ард түмэн ямар гунигтай байдалд ордгийн сонгодог жишээ болох вий.

/Энхтуул, Р. Оюун/

1. Эхэд юуны тухай өгүүлсэн бэ? /2 оноо/

.....

2. Эхийн гол санааг тодорхойлж бичнэ үү? /2 оноо/

.....

.....

3. Дараах хэлцүүдийг утга санаатай нь зөв харгалзуулаарай? /2 оноо/

- | | |
|------------------------------|------------------------|
| 1. Алтан аяганаас ус уух | A. Санаа нийлэх |
| 2. Айхын бараа идэхийн нэмэр | B. Азтай |
| 3. Гэдсэндээ хөлөө хийлцэх | C. Ямарч нэмэргүй |
| 4. Ганзага нийлэх | D. Хоорондоо муудалцах |

4. “Цонхнуудтай” гэдэг үгийг үгийн бүтцээр задалж бичээрэй. /2 оноо/

.....

5. “Мал сүрэг малчин хүний тодорхойлолт болж явдаг” цэгийн оронд эхээс олж нөхөөрэй? /2 оноо/

.....

6. Үйлүүд нь нэгэн цагт зэрэгцэн болж буй өгүүлбэр зохиож бичнэ үү? /2 оноо/

.....

7. “Аав ээж, өвөг дээдсийн буян өсөж дэлгэрэх учиртай юм” өгүүлбэрийн онцолсон бүтээврийг зэрэгцэн холбох нөхцөлөөр солин найруулаарай? /1 оноо/

.....

8. Гадаад шинжийг илэрхийлсэн үг хоёр, дотоод шинжийг илэрхийлсэн хоёр үг бичнэ үү? /2 оноо/

9. Дараах үгсийг зөв бичээд дүрмийг тайлбарлаарай? /3 оноо/

- Яв+я
- Ботго+ыг
- Бэлчээр+л

10. Зохиолын төрлийг зохиолтой зөв харгалзуулаарай /5 оноо/

- | | |
|-------------|-----------------------------------|
| 1. Дууль | A. Халхын дөрвөн хан цол авсан нь |
| 2. Өгүүллэг | B. Шүхэрч Буниая |
| 3. Туурь | C. Харамчийхан |
| 4. Домог | D. Миний нутаг |
| 5. Шүлэг | E. Хуучин хүү |

11 Дараах үгсээс ЭГЭ бүтэц бүхий урт эгшигтэй үгийг олоорой. /1 оноо/

- A. B. C. D.

12. Заахын нөхцөл залгах үгийг олоорой. /1 оноо/

- A. B. C. D.

13. Дараах эхийг хөрвүүлээрэй. /5 оноо/

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

7-Р АНГИ

“Б” Хувилбар

Сурагчийн нэр:

Нацагдорж минь ийм л хүн байлаа

Нөхөр Нацагдоржийг хувьсгалаас өмнө зүс таних төдий явсаар 1921 оны долдугаар сард бие тулж танилцсан юм.

Нөхөр Нацагдорж бие нарийхан, нуруу тэгш шулуухан, царай цагаан, үс хөмсөг хар, цочмог харсан хүнд хялардуу юм уу гэмээр, ажиглавал тийм биш, нүдний цагаан их, зовхи нимгэн бөгөөд гар хуруу цэвэр гоолиг, царайлаг залуу байсан юм.

Монгол дээл өмсөх боловч мөн европ хувцас холимог хэрэглэдэг. Цамцны дээр монгол дээл өмсөж явна. Тэр үед ардын намын малгай гэж нэрлэж байсан ногоон хилэн малгай өмсөнө. Хааяа тоорцог өмсөнө. Тэгж явахдаа хувцас нь цэвэр бөгөөд ямар хувцас боловч биедээ тохирсныг эдэлнэ...

Нөхөр Нацагдорж зан ааш дөлгөөн даруу, үг цөөн, үерхэг нөхөрсөг, хүнийг хүндэтгэх нь дуурайлалтай, ихэмсэг бардам зан огт байхгүй, энгийн ярих буюу хурал дээр үг хэлэхийн өмнө нүдээ дээш харж бодлого тавьж байгаад ярихдаа удаан, болгоомжтой, оновчтой цөөхөн үгээр санал шүүмжлэлээ тавих бөгөөд ер илүү сул үг хэлэхгүй.

/Ө. Чимэд дуртгалаас/

1. Эхэд юуны тухай өгүүлсэн бэ? /2 оноо/

.....

2. Эхийн гол санааг тодорхойлж бичнэ үү? /2 оноо/

.....

.....

.....

3. Дараах хэлцүүдийг утга санаатай нь зөв харгалзуулаарай? /2 оноо/

1. Хүйтний ам цаашаа харж

Хөхүүрийн ам наашаа харах

В. Яаруу, бүтэлгүйтэх

2. Нүглийн нүдийг гурилаар

хуураад яанам.

А. Малчин хүний

сэтгэл тэнийдэг.

3. Мордохын хазгай

Д. Эхнээсээ бүтэхгүй

4. Бушуу туулай борвиндоо баастай

С. Төгс хийх

4. “Сэдвийнхээ” гэдэг үгийг үгийн бүтцээр задалж бичээрэй. /2 оноо/

.....

5. “Нацагдоржийг хувьсгалаас өмнө таних төдий явсаар бие тулж танилцсан юм.” цэгийн оронд эхээс олж нөхөөрэй? /2 оноо/

.....

6. Үйлүүд нь нэгэн цагт зэрэгцэн болж буй өгүүлбэр зохиож бичнэ үү? /2 оноо

.....

7. “Нүдний цагаан их, зовхи нимгэн **бөгөөд** гар хуруу цэвэр гоолиг, царайлаг залуу байсан юм.” өгүүлбэрийн онцолсон үгийг зэрэгцүүлэн холбох үгээр солин найруулаарай? /1 оноо/

8. Гадаад шинжийг илэрхийлсэн үг хоёр, дотоод шинжийг илэрхийлсэн хоёр үг бичнэ үү? /2 оноо/

9. Дараах үгсийг зөв бичээд дүрмийг тайлбарлаарай? /3 оноо/


- хурга+ыг
- хувцас+л
- хүргэ+е

10. Зохиолын төрлийг зохиолтой зөв харгалзуулаарай /5 оноо/

- | | |
|-------------|------------------------|
| 1. Дууль | A. Мэргэн Жа Гүн |
| 2. Өгүүллэг | B. Эрээн цоохор |
| 3. Туурь | C. Бурханбогд аав хоёр |
| 4. Домог | D. Оюун түлхүүр |
| 5. Шүлэг | E. Харамчийхан |

11 Дараах үгсээс ЭГЭ бүтэц бүхий урт эгшигтэй үгийг олоорой. /1 оноо/

- A.  B.  C.  D. 

12. Заахын  нөхцөл залгах үгийг олоорой. /1 оноо/

- A.  B.  C.  D. 

13. Дараах эхийг хөрвүүлээрэй. /5 оноо/

